



UNDORHAAN

Утас: 7700 3322  
И-мэйл хаяг: info@undorhaan.mn

Мо-гол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8-в хороо, Сүхбаатарын талбай-2,  
Сэнтрал Тауэр, 17 давхар

2026 7 08

26/10

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн хувьцааг  
эргүүлэн худалдан авах  
тухай

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.5 болон 49.10.1 дэх заалт, 55 дугаар зүйлийн 55.2 болон 55.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Өндөрхаан ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг өсгөх зорилгоор компанийн ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөний хүрээнд хийгдэж буй бүтцийн өөрчлөлтийг нийцүүлэн нийт 300,000,000 төгрөг хүртэлх үнийн дүнтэй тэнцэх Компанийн хувьцааг энэ тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасан нөхцлийн дагуу олон нийтээс худалдан авч, халааслах; Хоёрдугаар хавсралтаар “Өндөрхаан” хк-ийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах журам” батлахаар тус тус **ШИЙДВЭРЛЭСҮГЭЙ.**
2. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл олгосон өдрөөр тасалбар болгохоор **ТОГТООСУГАЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах, хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулж, хэрэгжилтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /ААзбаяр/-д **ДААЛГАСУГАЙ.**
4. Энэхүү тогтоол болон журмын нэмэлт, өөрчлөлтийг хувьцаа эзэмшигчдэд хууль тогтоомж, холбогдох журмын дагуу мэдээлэх, шаардлага хүлээн авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох тайлан, мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т.Цогтцэнгэл/-д үүрэг **БОЛГОСУГАЙ.**



Ч.ГАНХУЯГ



Өндөрхаан ХК-ийн Толоолон Удирдах Зөвлөлийн  
2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 1/тоот  
ХК тогтоолын Хавсралт № 1

| №  | <b>ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦААГ<br/>ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|----|------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1  | Хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ /төгрөг/                                 | 14,526.59 төгрөг<br>11,150                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 2  | Эргүүлэн худалдан авах нийт хувьцааны тоо                                    | 20,000 ширхэг хүртэл<br>3,376 ↑                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 3  | Эргүүлэн худалдан авах нийт үнийн дүн /төгрөг/                               | 300,000,000 төгрөг хүртэл                                                                                                                                                                                                                                                                                                              |
| 6  | Хувьцааг олон нийтээс эргүүлэн худалдаж авах захиалгын хугацаа               | Компани нийтэд хувьцааг эргүүлэн худалдан авч халааслах мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд                                                                                                                                                                                                                              |
| 8  | Мэдээлэл түгээх                                                              | Хувьцааг олон нийтээс худалдан авах захиалгыг авч хэлбэгдох бүртгэлийг эрх бүхий байгууллага бүртгэснээс хойш ажлын 3 хоногийн дотор Компанийн <a href="http://www.ardholdings.com">www.ardholdings.com</a> болон Монголын хөрөнгийн биржийн <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a> цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. |
| 9  | Захиалга хүлээн авах байгууллага                                             | Ард Секюритиз УЦК ХХК<br>Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17 дугаартай Блю Скай барилгын 9 давхар.                                                                                                                                        |
| 10 | Захиалга хүлээн авах хэлбэр                                                  | Бичгээр (Central Tower 101 тоот) эсхүл цахимаар ( <a href="mailto:support@ardsecurities.com">support@ardsecurities.com</a> )                                                                                                                                                                                                           |